



Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 23

№ 357

Улаанбаатар
хот

Улсын үйлдвэрийн газар байгуулах
тухай

БНМАУ-ын "Аж ахуйн нэгжийн тухай хуулийг" үндэслэн
Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1.Автобусны I-р баазыг татан буулгах "Автобус-I" компани
/УУГ/ байгуулсугай.

2.Автобусны-I компанийн дүрмийг хавсралт ёсоор батал-
сугай.

3.Тус компаний дүрмийн санг 19,4 сая төгрөгөөр баталсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭГХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭЭШИ

Ц.БОЛДСАЙХАН



43

Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх
захиргааны 1991 оны 384 тоот тогтоолын
хавсралт.

"АВТОБУС-1" КОМПАНИЙН ДҮРЭМ.

Нэг.Ерөнхий зүйл.

1.Автобус-1 компани нь төрийн өмчийн хэлбэртэй оршин
тогтнож байгаа,ал ахуйн биеэ даасан нэгж мөн.

2."Автобус-1" компанийн зорилго нь нийслэлийн хөдөлмөрч-
дийн зорчигч тээврийн үйлчилгээг бүрэн дүүрэн хангахад оршино.

3.Тус компани нь оөрийн үйл ажиллагаагаа явуулахын
тулд банкинд харилцах данстай байхыг хамт бусад төр,ал ахуйн
байгууллага,хоршоолол хувь хүмүүстэй биеэ даасан гэрээ хэлэлцээр
байгуулаж ажиллах хуулийн этгээд байна.

4."Автобус-1"компани нь бүхий л үйл ажиллагаандаа
хууль тогтоомж,сахилгыг нарийн чанд сахин биелүүлж,өөрт олгогдсон
эрхээ төрийн болон хамт олныхоо ашиг сонирхолд нийцүүлэн амиллана.

5."Автобус-1" компанийг татан буулгах,шинээр өөрчлөн
зохион байгуулахыг түүнийг харъяалдаг эрх бүхий дээд байгууллага
шийдвэрлэнэ.

6."Автобус-1"компани нь улсын бүртгэлд бүртгүүлж,
Сүхбаатарын дүүргийн нутаг дэвсгэрт байрлана.

7."Автобус-1"компани нь тогтоосон дурмаар хийсэн
тэмдэг,бичгийн нүүр,тушаал,албан бичгийн баланстай байж,нягтлан
бодохын тайлан тэнцэл гаргаж байна.

Хоёр.Эд хөрөнгө

1."Автобус-1" компанийн хөрөнгө нь үндсэн ба
эсгэлтийн хөрөнгө,санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ.Тус компани
нь эд хөрөнгөө БНМАУ-ын хууль тогтоомж болон дүрэмд нийцүүлэн
үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмшин,ашиглаж захиран
зарцуулна.

2.Тус компанийн ажилчин,албан хаагч нь төрийн
өмчийг хайрлан хамгаална.Төрийн өмч хөрөнгийг идэж ашигласан
буюу бусад хэлбэрээр хохирол учруулсан гэм буруутанд хууль
тогтоомжийн заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.Тус компанийн хөрөнгийг бүрдүүлэх эх үүсвэр нь
ажил үйлчилгээний болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого,
улсын төсвийн хөрөнгө,бүх төрлийн зээл,бусад эх үүсвэр байна.

Турав.Үйлчилгээ, ая ахуйн үйл ажиллагаа

1.Тус компани нь үйлчилгээ, ая ахуйн үйл ажиллагаагаа байгуулсан гэрээний үүргийн дагуу зорчигч тээврийн өөрийн өртгийг хямдруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн явуулна.

2.Тус компани нь Автобусны үйлчилгээг батлагдсан чиглэл маршрут, цагийн хувзарь графیکیн дагуу явуулан үйлчилгээний мигд ажиллагааг хангана. Үйлчилгээний чиглэл маршрут шинээр нээх, хаах, үйлчилгээний үр ашигтайгаар өөрчилөн зохион байгуулах, саналаа боловсруулан удирдах дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх үүрэгтэй.

3.Тус компани нь Автобусны үйлчилгээний талаар үйлчилж байгаа газар нутгийн хөдөлмөрчдийн эрэлт хэрэгцээг байнга судлаж тэдэнтэй өргөн харилцаатай амиллана.

4.Тус компани нь өөрийн санхүүгийн нөөцийг хэмнэлттэйгээр зориулалтын дагуу зарцуула, төрийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж удирдах дээд байгууллагатайгаа байгуулсан гэрээгээ цаг хугацаанд нь үүнээ, тогтоосон журмын дагуу эд хөрөнгийн тооллого явуулна.

5.Тус компани нь нягтлан бодох анхан шатны болон статистикийн бүртгэлийг үнэн зөв хөглөж бүртгэл тооцооны зөвхөн дэвшилтэд арга барал, техник хэрэгсэл нэвтрүүлэн мэдээ тайлан тэнцлийг батлагдсан маягтаар гаргаж зохих дээд байгууллагад өгч байна.

6.Тус компани нь тогтоосон норм нормативийг үндсэнлэн техникийн засвар үйлчилгээний нарийвчилсан графیکیн дагуу өөрийн хөдлөх бүрэлдэхүүнийг техникийн үйлчилгээнд оруула, урсгал засварыг цаг хугацаанд нь шуурхай засварлаж байна.

7.Хүн тээврийн үйлчилгээнд онцгой амжилт гаргасан хүмүүст БНМАУ-ын хөдөлмөрийн баатар болон бусад хүндэт цол, төрийн шагнал, одон медалиар шагнуулах саналаа дээд байгууллагад уламжилна.

8.Тус компани нь орчноо бохирдуулахгүй байх түүний бүх талын арга хэмлээг авна.

Дөрөв."Автобус-1"компаний эрх

1.Хэрэгцээтэй түүхий эд, материалыг зохих газраас нь авч түүний ашиглалт, зарцуулалтанд хяналт тавьж ажиллана.

2.Тус компани нь банкын дахь зарлагын дансаар ажилчин, албан хаагчдын цалин хөлс, шагнал урамшуулал олгох гүйлгээ хийнэ.

3. Ажилчин албан хаагчдын эзэмшилд байгаа эд хөгшлыг картаар зохих эздэд нь хариуцуулан хяналт тавина.

4. Тус компани нь хууль тогтоомжинд заасны дагуу ажил мэргэжил хөслөх буюу албан тушаал хавсран ажиллахыг зөвшөөрөх, онцгой тохиолдолд ажилчин, албан хаагчдын хүсэлтийг харгалзан чөлөө олгох, нэг сарын цалингаас хэтрүүлэхгүйгээр урьдчилгаа олгох эрхтэй.

Тав. Удирдлага зохион байгуулалт

1. Тус компаний захиралыг харьяалах дээд байгууллага гэрээний үндсэн дээр томилно.

2. Компаний захирал нь компаний бүх амыг зохион байгуулалт түүний хөгжил, үйл ажиллагааны үр дүнг бүрэн хариуцана.

Захирал нь бүх дээд шатны болон бусад газруудтай баазаа төлөөлөн харилцаж түүхий эд, хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, эрх хэмлээнийхээ дотор тушаал, заавар, гаргах, хөдөлмөрийн хуулийн дагуу ажилчин, албан хаагчдыг амилд авах, халах тэдгээрийг шагнаж урамшуулах, тэтгэмж тусламж олгох, сахилга батын арга хэмлээ авах эрхтэй.

3. Компаний захиргаа нь дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран хамтын гэрээ байгуулж, уг гэрээний үүргээ цаг тухайд нь биелүүлж амиллана.

4. Тус компаний захиргаа нь хөдөлмөрийн дотоод дүрмээ батлах, өөрчлөх, шагнаж болон нийгэм соёлын арга хэмлээний фондыг төлөвлөн батлах түүнээс амиллагсдыг шагнаж бусад хөнгөлөлт олгох эрхтэй.

5. "Автобус-1" компани нь өөрт шаардлагатай сэлбэг материалыг олж нийлүүлэх, хамтран амиллах талаар гадаад худалдааны эрхээ эдлэнэ.